



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО



МОНГОЛ УЛСЫН  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧ ТАНАА



УЛААНБААТАР ХОТ  
2021 ОН



Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
**СОНГУУЛЬ**

**2021**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ**

Хэвлэлд бэлтгэсэн: Б.Ууганцэцэг

Хянасан: Д.Бат-Эрдэнэ  
Ц.Баасандэлгэр

© Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо 2021 он

Энэхүү гарын авлагыг зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, олшруулах, нийгмийн сүлжээнд тараах, цахим мэдээллийн санд оруулах, зэргээр ашиглахыг хориглоно.

Хэвлэсэн огноо: 2021.04.21

Хэвлэсэн хувь: 100 ширхэг


## АГУУЛГА

5 - 9  
ХУУДАС НЭР ДЭВШИГЧИЙН  
БҮРДҮҮЛЭХ БАРИМТ  
БИЧГИЙН ЖАГСААЛТ



11-16  
ХУУДАС ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН  
МЭДҮҮЛГИЙГ ЦАХИМ  
СИСТЕМД ҮҮСГЭХ,  
МЭДҮҮЛЭХ,  
БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧИЙН  
**БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД НЭР ДЭВШИГЧИЙН БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

*Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:*

### 1. Нэр дэвшүүлсэн тухай хуралдааны шийдвэр

Намаас нэр дэвшүүлэх асуудлыг тухайн намын төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

Намууд хамтарч сонгуульд нэр дэвшүүлэх тухай асуудлыг нам тус бүр төлөөллийн төв байгууллагынхаа хуралдаанаар шийдвэрлэнэ.

### 2. Нэр дэвшигчийн бичгээр өгсөн зөвшөөрөл

Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

*Маягтыг [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn) цахим хуудсаас авах боломжтой.*

3. Нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай Авлигатай тэмцэх газрын тодорхойлолт

Нэр дэвшигч нь <https://meduuleg.iaac.mn/> цахим системд 2020 оны хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлж баталгаажуулан, гарын үсэг зурсан “Баталгааны маягт”-ыг Авлигатай тэмцэх газарт 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс өмнө хүргүүлж, тус газраас уг тодорхойлолтыг авна.

Иймд цахим системд нэвтрэхийн тулд нэр дэвшигчийн и-мэйл хаяг болон бусад шаардлагатай мэдээллийг 2021 оны 5 дугаар сарын 03-ны өдрийн дотор **Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтэс /Утас: 70112489, 70110252/-тэй** холбогдож урьдчилан хүргүүлсэн байх шаардлагатай.

4. Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, дэд дарга, захирал, дэд захирал, Засгийн газраас байгуулсан хамтын удирдлагын байгууллагын орон тооны болон орон тооны бус гишүүн бол ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн шийдвэрийн хуулбар

5. Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын өр төлбөртэй эсэх талаарх Улсын Дээд шүүхийн лавлагаа

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5, 26 дугаар зүйлийн 26.2.1-д заасан лавлагааг олгоно.



## Лавлагаа хүсэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд нэр дэвшсэнийг тодорхойлох баримт;
- Лавлагаа хүссэн өргөдөл; **/Загвар1/ Өргөдлийн загварыг**

<http://gec.gov.mn/>, <http://www.supremecourt.mn/> цахим хуудсаас авах боломжтой.

- Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа болон батлан даалтын талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүхэд хариуцагчаар оролцож байсан эсэх мэдээлэл; **/Загвар2/ Мэдээллийн загварыг** <http://gec.gov.mn/>, <http://www.supremecourt.mn/> цахим хуудсаас авах боломжтой.

**Лавлагаатай холбоотой асуудлаар Улсын Дээд шүүх /Утас: 51-261092, 51-261878/-тэй холбогдож мэдээлэл авах боломжтой.**

6.Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх, аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх Татварын ерөнхий газрын тодорхойлолт

**А.**Нэр дэвшигч [www.etax.mta.mn](http://www.etax.mta.mn) цахим хуудаст хандаж татварын хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх тодорхойлолтыг авна.

Иргэн, хуулийн этгээд нь татвар төлөгчөөр бүртгүүлснээр Цахим татварын системийн хэрэглэгч болж, татварын лавлагаа, тодорхойлолт авах боломжтой болно.

Иймд иргэн [www.etax.mta.mn](http://www.etax.mta.mn) цахим хуудаст хандан татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Бүртгүүлэх зааврыг Сонгуулийн ерөнхий хорооны [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn) болон Татварын ерөнхий газрын [www.mta.mn](http://www.mta.mn) цахим хуудсаас авах боломжтой.

**Б.**Нэр дэвшигч аль нэг компанийн 51 түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол [www.etax.mta.mn](http://www.etax.mta.mn) цахим хуудаст хандаж байгууллагын татварын тодорхойлолтыг авна.

*Тодорхойлолтыг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан /захирал, нягтлан бодогч/ эсхүл нэр дэвшигч өөрөө цахим татварын системээс авах боломжтой.*

Тодорхойлолт авах дэлгэрэнгүй зааврыг Сонгуулийн ерөнхий хорооны [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn) болон Татварын ерөнхий газрын [www.mta.mn](http://www.mta.mn) цахим хуудсаас авах боломжтой.

**Лавлагаатай холбоотой асуудлаар Татварын ерөнхий газар**

**/Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга Б.Батсайхан Утас:51-261698/, 90903346/ -тай холбогдож мэдээлэл авах боломжтой.**

#### 7.Нэр дэвшигчийн намтар

Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт.

*Маягтыг [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn) цахим хуудсаас авах боломжтой.*

#### 8.Нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбар

#### 9. Нэр дэвшигчийн төрсний гэрчилгээ

Хэрэв төрсний гэрчилгээ байхгүй бол Монгол Улсын уугуул иргэн болохыг нотолсон архивын лавлагаа авна. Лавлагааг Архивын ерөнхий газраас олгох бөгөөд нэр дэвшигч өөрөө эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч авна.

**Лавлагаатай холбоотой асуудлаар Үндэсний төв архивын Мэдээлэл, лавлагааны төв /эрхлэгч С.Шижирбаатар Утас: 77002087, 99055872/-тэй холбогдож мэдээлэл авах боломжтой.**

#### 10. Сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан тухай хил хамгаалах байгууллагын тодорхойлолт

Лавлагаа, мэдээллийг хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан, иргэнд эсхүл түүнтэй хамаарал бүхий хууль ёсны этгээд болон түүнийг төлөөлөх эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчид хууль тогтоомжид заасан журмын дагуу өгнө.

Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл, лавлагаа авах хүсэлтэд:

- тухайн хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр;
- регистрийн дугаар; /төрсөн он, сар, өдөр/
- хил нэвтрэх эрхийн баримт бичиг /гадаад паспорт/-ийн дугаар;
- лавлагаа гаргуулах шалтгаан, ашиглах зорилго;
- нэвтэрсэн боомтын нэр, огноо, шүүлгэсэн хугацаа;
- хувь хүний оршин суугаа газар, харилцах утасны дугаарыг тодорхой тусгаж, иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана.

Лавлагаа хүссэн маягтыг [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn), [www.bpo.gov.mn](http://www.bpo.gov.mn)/ цахим хуудсаас авах боломжтой.

**Лавлагаатай холбоотой асуудлаар Хил хамгаалах ерөнхий газар /Нууцын албаны цахим бүртгэлийн системийн лавлагаа, нууцлал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч Ч.Мөнхтамир, утас:92119366/-тай холбогдож мэдээлэл авах боломжтой.**



11. Нэр дэвшигчийн эцэг, эхийг Монгол Улсын харьяат болохыг нотлох иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг

Нэр дэвшигчийн эцэг, эхийн иргэний үнэмлэх байхгүй тохиолдолд архивын лавлагаа авна.

**Лавлагаатай холбоотой асуудлаар Үндэсний төв архивын Мэдээлэл, лавлагааны төв /эрхлэгч С.Шижирбаатар Утас: 77002087, 99055872/-тэй холбогдож мэдээлэл авах боломжтой.**

12. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасны дагуу төрийн аудитын дээд байгууллагаар хянуулсан сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт

Нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг 2021 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 24:00 цагаас өмнө Төрийн аудитын дээд байгууллага /Үндэсний аудитын газар/-д хүргүүлэх бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн дотор дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулна.

**Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргуулах үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Үндэсний аудитын газар /Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, утас:51-260949/-тай холбогдон мэдээлэл авах боломжтой.**

13. Нэр дэвшигчийн эрүүл мэндийн талаарх эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ажлын хэсгийн дүгнэлт

Нэр дэвшигчийн эрүүл мэндийн талаарх дүгнэлт гаргах ажлыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна.

**Дүгнэлт гаргахтай холбоотой асуудлаар Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Уламжлалт анагаах ухааны хэлтсийн дарга М.Оюунчимэг, утас:51-261721/-тай холбогдож мэдээлэл авах боломжтой.**

14. Ял эдэлж байгаа эсэх болон Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн эсэх талаарх Цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа

Ял эдэлж байгаа эсэх талаарх болон авлига албан тушаалын гэмт хэргийн талаарх хоёр төрлийн лавлагааг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Статистик, мэдээллийн хэлтсийн Лавлагааны сангаас олгоно.

Лавлагааны сан нь Баянзүрх дүүргийн 2 дугаар хороо, Цагдаа хотхон, Дотоодын цэргийн 805 дугаар ангийн үүдэнд байрлах Цагдаагийн ерөнхий газрын Төв архивын байрны 1 дүгээр давхарт байрлаж байна.



## Лавлагааны сангийн 1 дүгээр цонхоор тусгайлан үйлчилнэ.

Утасны дугаар: 70191060, 70191089

Лавлагаа авахдаа өөрийн иргэний үнэмлэх болон түүнтэй адилтгах баримт бичиг, эсхүл тухайн хүн өөрөө ирэх боломжгүй тохиолдолд бусдад олгосон итгэмжлэл болон итгэмжлэгдсэн хүний иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичиг, архиваас үзүүлэх **төлбөрт үйлчилгээний хураамж болох 500 төгрөгийг төрийн сан дахь Цагдаагийн ерөнхий газрын 100900012027 дугаар дансанд тушаасан баримт / аль ч арилжааны банкинд тушааж болно/ зэргийг бүрдүүлсэн байна.**

Ял эдэлж байгаа эсэх лавлагааг “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт”-ын маягтаар, авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож байсан эсэх талаарх лавлагааг албан бичгээр тус тус олгоно.

Нам, эвслээс ирүүлсэн албан бичгийн дагуу лавлагаа олгож болох бөгөөд албан бичигт лавлагаа авах эрх зүйн үндэслэл болон лавлагааг төлөөлөн авах хүний мэдээллийг тусгаж, тухайн нам, эвслээс **нэр дэвшигчийн /ургийн овог, эцэг /эх/-ийн болон түүний нэр, регистр, холбогдох утасны дугаар/-ыг үнэн зөв, гүйцэд, гаргацтай бичиж, архиваас үзүүлэх төлбөрт үйлчилгээний хураамж болох 500 төгрөгийг төрийн сангийн 100900012027 дугаар дансанд тушаасан баримт** зэргийг хавсаргаж ирүүлнэ.

15. Нэр дэвшигчийн 4x3 хэмжээтэй зураг мөн файлаар (600dpi нягтаршилтай байх)

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиас:*

*54.3.Саналын хуудас нэр дэвшигчийн зурагтай байна.*

16. Нэр дэвшүүлсэн нам, эвслийн дүрэм /эвслээс нэр дэвшүүлсэн тохиолдолд эвслийн гэрээ/





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧ ТА

- ✔ 2020 оны Хөрөнгө, орлогын мэдүүлэгт 2020 оны 1 дүгээр сарын 01-ээс 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлого, эзэмшил, өмчлөлийн хөрөнгийг мэдүүлнэ.
- ✔ 2021 оны 5 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, системд баталгаажуулна.
- ✔ Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогыг үнэн зөв мэдүүлэх ба мэдүүлгийн “ТАЙЛБАР” хэсэгт тухайн орлого, хөрөнгийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй бичнэ.





# ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ (ХОМ)-ИЙГ <https://meduuleg.iaac.mn> ЦАХИМ СИСТЕМАД ХЭРХЭН МЭДҮҮЛЭХ ВЭ?

## 1-Р АЛХАМ: ЦАХИМ СИСТЕМАД ЭРХ ҮҮСГЭХ, НЭВТРЭХ



ХОМ-ийг цахимаар мэдүүлэх эрхийг система тусгайлан үүсгэх тул өөрийн ашиглаж буй и-мэйл хаяг, холбоо барих утасны дугаар болон бусад шаардлагатай мэдээллийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс/утас: 70112489, 70110252/-т 2021.05.03-ны дотор урьдчилан хүргүүлнэ.



Нэвтрэх нэр хэсэгт системд бүртгүүлсэн **и-мэйл** хаягийг бичнэ.


Системд бүртгүүлсэн и-мэйл хаягт очсон **нууц үгийг** бичнэ.

Системд нэвтрэх "Нууц үг"-ийг сэргээх эсхүл өөрчлөх бол уг **холбоос дээр дарж**, нууц үгийг **сэргээж** авна.




Цахим системд нэвтрэх нэр буюу и-мэйл хаягаа өөрчлөх тохиолдолд **зөвхөн өөрөө** АТГ-т хандаж солиулна.

## 2-Р АЛХАМ: ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ МЭДҮҮЛЭХ



ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН  
БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМ



ХАРИУЦСАН АЖИЛТАН

Сайн Нэр: \_\_\_\_\_

Ажлын утас: 7011- 0252

Мэдүүлгээ системийн "засварлах" үйлдлийг сонгож, орлого, хөрөнгө тус бүрээр мэдүүлж, хадгална.

Засварлах

ХАСХОМ жагсаалт	Он	Байгууллага	Албан тушаал	Үүссэн огноо	Баталгаажуулсан огноо	Төлөв	Үйлдэл
1	2020*					✖	→ ←

**Мэдүүлэг гаргагч** | Гэр бүлийн байдал... | Орлого | Орон сууц | Тээврийн | Мал, аж ахуй

**Үндсэн мэдээлэл**

Ургийн овог:  Эцэг/эх/-ийн нэр:

Нэр:  Регистрийн дугаар:

**Эрхэлж буй ажил**

Байгууллагын нэр:

Албан тушаал:

**Боловсрол, мэргэжил**

Боловсрол:

Мэргэжил:

**Холбоо барих**

Гар утас:

Шаардлагатай үед холбоо барих:

Цахим шуудангийн хаяг:

**Оршин суугаа газрын хаяг**

Улс:

Аймаг/Нийслэл:

Сум/Дүүрэг:

Хороолол:

Баг/Хороо:

Хаяг:

**Төрсөн газар**

Улс:

Аймаг/Нийслэл:

Сум/Дүүрэг:

Хаяг:

**Үндсэн харьяа**

Улс:

Аймаг/Нийслэл:

Сум/Дүүрэг:

Хаяг:



Та өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлогыг мэдүүлэхэд орон сууц, газар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний дугаар, хадгаламж, эзэмшиж буй дансны хуулга зэрэг шаардлагатай мэдээлэл, баримт бичгүүдийг **УРЬДЧИЛАН БЭЛТГЭСЭН** байхад анхаарна уу.



### 3-Р АЛХАМ: ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ БАТАЛГААЖУУЛАХ



ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН  
БҮРДҮҮЛЭЛТИЙН СИСТЕМ



Нүүр хуудас

ХАРИУЦАН АЖИЛТАН

Овог нэр: \_\_\_\_\_  
Адрес утас: \_\_\_\_\_

Дэлгэрэнгүй

ХАСХОМ жагсаалт

Он	Байгууллага	Албан тушаал	Үүсэн огноо	Баталгаажуулсан огноо	Төлөв	Үйлдэл
2020*					✗	→ ←

Та ХОМ-ийг баталгаажуулахдаа жагсаалтын “дэлгэрэнгүй” товчийг сонгож, “дэлгэрэнгүй хуудас” хэсгээс ХОМ харах товчийг дарна.

Мэдүүлэгчийн мэдээлэл

Эцэг/эх/ийн нэр: \_\_\_\_\_ Нэр: \_\_\_\_\_ Регистрийн дугаар: \_\_\_\_\_  
Байгууллага: \_\_\_\_\_ Албан тушаал: \_\_\_\_\_


Мэдүүлэг гаргагч | Гэр бүлийн байдал | Орлого | Орон сууц | Тээврийн хэрэгсэл | Мал, аж ахуй | Газар

1.1 Мэдүүлэг гаргагч


Ургийн овог	_____	Эцэг эхийн нэр	_____	Өөрийн нэр	_____
Регистрийн дугаар	_____	Гэр утас	_____	Имэйл хаяг	_____
Оршин суугаа газрын хаяг	_____	Ажлын утас	_____		
		Гэрийн утас	_____		
Боловсрол, мэргэжил	_____	Байгууллагын нэр	_____		
Төрсөн газар	_____	Албан тушаал	_____		
Үндсэн харьяа	_____				

ХОМ харах

ХОМ харах



“ХОМ харах” товчийг дармагц “Баталгаажуулах” товч гарч ирэх бөгөөд **Баталгаажуулах** товчийг дарж мэдүүлгээ баталгаажуулна. Мэдүүлгээ баталгаажуулмагц “Таны ХОМ амжилттай баталгаажлаа” гэсэн мэдэгдэл харагдана.






### Таны ХОМ амжилттай баталгаажлаа.

Мэдүүлэг гаргагч					
Гэр бүлийн байдал ...					
Орлого					
Орон сууц...					
Тээрийн хэрэгсэл					
Мал, аж ахуй					
Газар					

1.1 Мэдүүлэг гаргагч					
Ургийн овог	_____	Эцэг эхийн нэр	_____	Өөрийн нэр	_____
Регистрийн дугаар	_____	Гэр утас	_____	Имэйл хаяг	_____
Оршин суугаа газрын хаяг	_____	Ажлын утас	_____		
		Гэрийн утас	_____		
Боловсрол, мэргэжил	_____	Байгууллагын нэр	_____		
Төрсөн газар	_____	Албан тушаал	_____		
Үндсэн харьяа	_____				



**Баталгааны маягт**

Баталгааны маягт ХОМ харах Халх

Үүний дараа **Баталгааны маягт** товчийг сонгоход системээс PDF хэлбэрээр уг маягтыг харуулах ба түүнийг хэвлэн гарын үсгээ зурж, АТГ-т хүргүүлнэ.



#### БАТАЛГААНЫ МАЯГТ

/Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай/

Дугаар..... он..... сар..... өдөр  
Баталгааны маягтыг хүлээн авсан огноо:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
2021 оны ээлжит сонгууль  
/Сонгуулийн хэлбэр, төрөл/

\_\_\_\_\_ /Нэр дэвшигчийн эцэг/эх/-ийн нэр, нэр/

(<https://mediuleg.iaac.mn/> цахим системд  
бүртгээдсэн имэйл хаяг)

\_\_\_\_\_ /Регистрийн дугаар/

ХОМ мэдүүлсэн он: 2020\*

ХОМ мэдүүлэх эрхийг цахим системд үүсгэсэн огноо: .....

ХОМ-ийг цахим системд баталгаажуулсан огноо, цаг, минут: .....

..... овогтой ..... өөрийн нэр/ миний бие Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.6 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь хэсэгт заасны дагуу Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын (<https://mediuleg.iaac.mn>) цахим системд үнэн зөв мэдүүлсэнээ баталж байна. Хөрөнгө, орлогыг мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвөл хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан,  
Мэдүүлэг гаргагч:

\_\_\_\_\_ /Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр/

\_\_\_\_\_ /Гарын үсэг/

Баталгааны хуудсыг хүлээн авсан,

\_\_\_\_\_ /Албан тушаал/

\_\_\_\_\_ /Овог, нэр/

\_\_\_\_\_ /Гарын үсэг/

\_\_\_\_\_ Баталгааны маягтыг хэвлэсэн огноо





**МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот - 38,  
Ж.Самбуугийн гудамж - 11, Засгийн газрын 11 дүгээр байр  
Сонгуулийн ерөнхий хороо

Утас: +(976) - 51 260975, 236302

Факс: +(976) - 11 326975

Веб сайт: [www.gec.gov.mn](http://www.gec.gov.mn)  
И-мэйл: [gecm@gec.gov.mn](mailto:gecm@gec.gov.mn)



**МОНГОЛ УЛСЫН  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот - 14250,  
Сүхбаатар дүүрэг, 5-р хороо,  
Сөүлийн гудамж - 41

Утас: +(976) - 7011-0252

+(976) - 7011-2489

Веб сайт: [www.iaac.mn](http://www.iaac.mn)